

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БАЯНХОНГОР АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аудитын код: БНА-2021/185/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот

2021 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер А.Цээням:

Утас: 70442424 Цахим хаяг: [tseenyama@audit.gov.mn](mailto:tseenyama@audit.gov.mn)

Ахлах аудитор Б.Должмаа

Утас: 88110538 Цахим хаяг: [doljmaab@audit.gov.mn](mailto:doljmaab@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
МЭЕГ	Мал эмнэлгийн Ерөнхий газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УМЭАЦТЛ	Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

## Агуулга

1.Төрийн аудитын санал дүгнэлт /эх хувь/ .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	13
3.Аудитын тайлан .....	13
3.1. Ерөнхий зүйл .....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	14
3.4. Материаллаг байдал .....	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	16
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
3.9. Аудитын илрүүлэлт .....	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	18
Аудитын зөвлөмж .....	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	19
4. Менежментийн захидал.....	20
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	23



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН МАЛ  
ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ДАРГА  
Л.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

2021.02.23 № 2/57

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г **АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ** Г

### **Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### **Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Мал эмнэлгийн Ерөнхий газрын дарга баталж, гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын дарга тайлагнасан байна.

Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй хувийн мал эмнэлгүүдтэй байгуулсан гэрээний гүйцэтгэлийг үнэлэх, ажил үйлчилгээний чанарын асуудлыг байгууллагын удирдлага хэрэгжүүлдэг.

2021 А4 ТООТ

• 005020997

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТӨРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Төгрөгөөр/
			Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>181,811,204.61</b>	<b>162,178,155.59</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	181,811,204.61	162,178,155.59
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	134,140,753.61	101,290,585.59
35110	Тусгай зориулалттай материал	134,140,753.61	96,748,985.59
35130	Эм боох материал	-	4,541,600.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	45,760,451.00	59,902,570.00
35410	Бичиг хэргийн материал	4,325,356.00	7,107,375.00
35420	Аж ахуйн материал	41,435,095.00	46,842,445.00
35440	Түлш, шатах тослох материал	-	5,277,690.00
35470	Бусад хангамжийн материал	-	675,060.00
35600	Мал амьтад	1,910,000.00	985,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>523,494,641.37</b>	<b>595,689,702.84</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	523,494,641.37	595,689,702.84
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	522,430,891.35	593,820,952.78
39201	Барилга, байгууламж, орон сууц	64,691,600.00	64,691,600.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(8,745,776.52)	(17,491,553.04)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	176,348,629.67	266,259,629.67
39204	Хуримтлагдсан элэгдэл	(107,112,518.70)	(133,650,567.90)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	397,400,120.88	475,500,749.68
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,680,927.62)	(102,621,335.37)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,907,800.00	49,262,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(6,378,036.36)	(8,129,570.26)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	1,063,750.02	1,868,750.06
39301	Програм хангамж	1,180,000.00	2,280,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(116,249.98)	(411,249.94)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>705,305,845.98</b>	<b>757,867,858.43</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>60,662.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	60,662.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	60,662.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	60,662.00

**Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>705,305,845.98</b>	<b>757,807,196.43</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	705,305,845.98	757,807,196.43
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		
51210	Өмнөх үеийн үр дүн	650,628,195.91	703,129,546.36
51220	Тайлант үеийн үр дүн	-	52,501,350.45
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	54,677,650.07	54,677,650.07
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>705,305,845.98</b>	<b>757,867,858.43</b>

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,436,843,423.68</b>	<b>1,950,322,706.82</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>940,714,403.68</b>	<b>399,539,816.82</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	940,714,403.68	399,539,816.82
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	940,714,403.68	399,539,816.82
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,040,300.00	2,080,100.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	938,674,103.68	397,459,716.82
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,496,129,020.00</b>	<b>1,550,782,890.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	663,594,600.00	708,493,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	663,594,600.00	708,493,100.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	832,534,420.00	842,289,790.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	517,503,500.00	714,193,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	315,030,920.00	128,096,790.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,731,537,577.70</b>	<b>1,897,821,356.37</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,731,537,577.70</b>	<b>1,897,821,356.37</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,715,203,887.71	1,866,946,915.13
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	79,354,800.00	100,828,800.00
210101	Үндсэн цалин	65,834,500.00	75,511,500.00
210102	Нэмэгдэл	10,149,300.00	21,946,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,371,000.00	3,371,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	9,919,400.00	13,611,900.00
210201	Тэтгэврийн даатгал	6,745,200.00	9,578,700.00

**Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210202	Тэтгэмжийн даатгал	793,600.00	1,008,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	634,700.00	806,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	158,700.00	201,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,587,200.00	2,016,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>12,758,700.00</b>	<b>23,717,891.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,865,900.00	1,817,459.00
210302	Түлш, халаалт	9,000,000.00	20,650,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,892,800.00	1,250,432.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>49,689,053.00</b>	<b>34,249,413.00</b>
210401	Бичиг хэрэг	6,922,800.00	4,978,856.00
210402	Тээвэр, шатахуун	31,712,200.00	20,859,498.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,154,644.00	3,853,159.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	266,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,539,409.00	3,122,100.00
210408	Бараа материал акталсны зардал	-	1,169,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>399,824,002.98</b>	<b>415,885,376.60</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	399,824,002.98	415,885,376.60
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>17,329,250.00</b>	<b>4,267,500.00</b>
210604	Урсгал засвар	17,329,250.00	4,267,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,128,231,417.82</b>	<b>1,150,245,384.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,126,804,037.82	1,148,219,026.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	102,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	749,520.00	750,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	315,960.00	376,780.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	134,178.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	400,000.00
210807	Газрын төлбөр	262,900.00	262,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>18,097,263.91</b>	<b>124,140,650.53</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,689,345.79	156,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,407,918.12	123,984,650.53
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>16,333,689.99</b>	<b>30,874,441.24</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>15,843,600.00</b>	<b>16,817,393.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,598,600.00	15,517,393.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,245,000.00	1,300,000.00



**Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	490,089.99	14,057,048.24
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	490,089.99	12,670,669.40
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		1,386,378.84
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>705,305,845.98</b>	<b>52,501,350.45</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>705,305,845.98</b>	<b>52,501,350.45</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,498,169,320.00</b>	<b>1,572,862,990.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,040,300.00</b>	<b>2,080,100.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,040,300.00	2,080,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,040,300.00	2,080,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,040,300.00	2,080,100.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,496,129,020.00</b>	<b>1,570,782,890.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	663,594,600.00	708,493,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	663,594,600.00	708,493,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	832,534,420.00	862,289,790.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	517,503,500.00	714,193,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	315,030,920.00	148,096,790.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,456,130,520.00</b>	<b>1,563,120,990.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,456,130,520.00</b>	<b>1,563,120,990.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,439,796,830.01</b>	<b>1,531,844,048.76</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	79,354,800.00	100,828,800.00
210101	Үндсэн цалин	65,834,500.00	75,511,500.00
210102	Нэмэгдэл	10,149,300.00	21,946,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,371,000.00	3,371,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	9,919,400.00	13,611,900.00
210201	Тэтгэврийн даатгал	6,745,200.00	9,578,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	793,600.00	1,008,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	634,700.00	806,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	158,700.00	201,700.00

**Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210205	Эрүүл мэндийн даатгал	1,587,200.00	2,016,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>12,758,700.00</b>	<b>23,717,891.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,865,900.00	1,817,459.00
210302	Түлш, халаалт	9,000,000.00	20,650,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,892,800.00	1,250,432.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>49,118,359.00</b>	<b>36,516,959.00</b>
210401	Бичиг хэрэг	10,004,656.00	6,158,100.00
210402	Тээвэр, шатахуун	26,831,100.00	20,565,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,154,644.00	8,545,659.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	360,000.00	266,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,767,959.00	980,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>22,440,400.00</b>	<b>8,501,615.60</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,550,000.00	7,671,915.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,890,400.00	829,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>20,015,200.00</b>	<b>11,613,400.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,081,200.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	5,194,750.00
210604	Урсгал засвар	18,934,000.00	6,418,650.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,246,189,971.01</b>	<b>1,337,053,483.16</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,244,762,591.01	1,335,027,125.16
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	102,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	749,520.00	750,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	315,960.00	376,780.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	134,178.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	400,000.00
210807	Газрын төлбөр	262,900.00	262,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>16,333,689.99</b>	<b>31,276,941.24</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>15,843,600.00</b>	<b>17,219,893.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,598,600.00	15,517,393.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,245,000.00	1,702,500.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>490,089.99</b>	<b>14,057,048.24</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	490,089.99	12,670,669.40
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		1,386,378.84
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>42,038,800.00</b>	<b>9,742,000.00</b>

**Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>42,038,800.00</b>	<b>9,742,000.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>42,038,800.00</b>	<b>9,742,000.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	42,038,800.00	9,742,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	42,038,800.00	9,742,000.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(42,038,800.00)</b>	<b>(9,742,000.00)</b>
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	0.00	0.00		0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>		<b>0.00</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	705,305,845.98	705,305,845.98
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	<b>705,305,845.98</b>	<b>705,305,845.98</b>
D01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	0.00	0.00	<b>705,305,845.98</b>	<b>705,305,845.98</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>54,677,650.07</b>	<b>650,628,195.91</b>	<b>705,305,845.98</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	52,501,350.45	52,501,350.45
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	<b>54,677,650.07</b>	<b>703,129,546.36</b>	<b>757,807,196.43</b>



## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	710,493,100.00	697,902,530.60	12,590,569.40	98.23
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	710,493,100.00	697,902,530.60	12,590,569.40	98.23
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	691,484,500.00	680,682,637.60	10,801,862.40	98.44
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	100,828,800.00	100,828,800.00	-	100.00
210101	Үндсэн цалин	75,511,500.00	75,511,500.00	-	100.00
210102	Нэмэгдэл	21,946,300.00	21,946,300.00	-	100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,371,000.00	3,371,000.00	-	100.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	13,611,900.00	13,611,900.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	9,578,700.00	9,578,700.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,008,300.00	1,008,300.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	806,600.00	806,600.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	201,700.00	201,700.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,016,600.00	2,016,600.00	-	100.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	26,756,300.00	23,717,891.00	3,038,409.00	88.64
210301	Гэрэл, цахилгаан	1,865,900.00	1,817,459.00	48,441.00	97.40
210302	Түлш, халаалт	20,655,000.00	20,650,000.00	5,000.00	99.98
210303	Цэвэр, бохир ус	4,235,400.00	1,250,432.00	2,984,968.00	29.52
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	39,595,900.00	36,516,959.00	3,078,941.00	92.22
210401	Бичиг хэрэг	7,461,700.00	6,158,100.00	1,303,600.00	82.53
210402	Тээвэр, шатахуун	20,565,900.00	20,565,900.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,824,600.00	8,545,659.00	278,941.00	96.84
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	266,800.00	266,800.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,476,900.00	980,500.00	1,496,400.00	39.59
2105	<b>Нормативт зардал</b>	8,818,300.00	8,501,615.60	316,684.40	96.41
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,925,600.00	7,671,915.60	253,684.40	96.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	892,700.00	829,700.00	63,000.00	92.94
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	16,796,000.00	16,555,400.00	240,600.00	98.57
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,946,000.00	4,942,000.00	4,000.00	99.92
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,350,000.00	5,194,750.00	155,250.00	97.10



**Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210604	Урсгал засвар	6,500,000.00	6,418,650.00	81,350.00	98.75
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>485,077,300.00</b>	<b>480,950,072.00</b>	<b>4,127,228.00</b>	<b>99.15</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	481,861,900.00	477,823,714.00	4,038,186.00	99.16
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	102,500.00	102,500.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	750,000.00	750,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	450,000.00	376,780.00	73,220.00	83.73
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000.00	134,178.00	15,822.00	89.45
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	262,900.00	262,900.00	-	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>19,008,600.00</b>	<b>17,219,893.00</b>	<b>1,788,707.00</b>	<b>90.59</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>19,008,600.00</b>	<b>17,219,893.00</b>	<b>1,788,707.00</b>	<b>90.59</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,277,100.00	15,517,393.00	1,759,707.00	89.81
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,731,500.00	1,702,500.00	29,000.00	98.33
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>710,493,100.00</b>	<b>697,902,530.60</b>	<b>12,590,569.40</b>	<b>98.23</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>708,493,100.00</b>	<b>695,822,430.60</b>	<b>12,670,669.40</b>	<b>98.21</b>
122005	Орон нутгийн төсвөөс	708,493,100.00	695,822,430.60	12,670,669.40	98.21
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>2,000,000.00</b>	<b>2,080,100.00</b>	<b>(80,100.00)</b>	<b>104.01</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	2,080,100.00	(80,100.00)	104.01
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	-	#DIV/0!
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	-	#DIV/0!
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>58.00</b>	<b>53.00</b>	<b>5.00</b>	<b>91.38</b>
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>58.00</b>	<b>53.00</b>	<b>5.00</b>	<b>91.38</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	53.00	48.00	5.00	90.57
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	-	100.00



## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

			/ төгрөгөөр /
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>832,534,420.00</b>	<b>842,289,790.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	832,534,420.00	840,903,411.16
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>832,534,420.00</b>	<b>840,903,411.16</b>
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>832,534,420.00</b>	<b>840,903,411.16</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	832,534,420.00	840,903,411.16
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		1,386,378.84
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>832,534,420.00</b>	<b>842,289,790.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>832,534,420.00</b>	<b>842,289,790.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	517,503,500.00	714,193,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	315,030,920.00	128,096,790.00

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн захирагч Л.Оюун-Эрдэнэ танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгө захиран зарцуулах шийдвэрийг тухай бүр гаргаж, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, бараа материалд тавих хяналтыг сайжруулах, өөрийн орлогыг нэмэгдүүлэх, түүнийг тухай бүр харилцах дансанд төвлөрүүлэх, хугацаа дууссан вакциныг дээд шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хувийн мал эмнэлгүүдэд өгч байгаа санхүүжилтийн зарцуулалтын баримтад тавих хяналтыг сайжруулах, эд хөрөнгийн картыг бүрэн хөтлөх зэрэг зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 19-ний өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, 2020 оны 02 дугаар сарын 23-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2021.01.25-ний өдөр ирүүлсэн байна.



### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Тус байгууллага “Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг баталгаажуулах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжигч байгууллага болох” зорилго тавьж ажилласан байна.

Байгууллагын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль
- Аж ахуйн нэгжийн тухай хууль
- Хүнсний тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хуулиудад нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт


Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон аудитор хийж гүйцэтгэлээ.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар нь “Хас эрин орчил” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн Dynamic онлайн санхүүгийн программ хангамж ашигладаг байна.

Тус байгууллага нь ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А-385 дугаар тушаалаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, 2019 оны 11 дүгээр сарын 15-ний өдрөөс эхлэн мөрдсөн байна.

Тус байгууллагад дотоод хяналтын нэгж байхгүй ба 2020 онд ЗХЖШ-аас болон бусад хөндлөнгийн байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.



### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг зардлын дүн хэт өндөр тул 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 03 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 1.0 хувиар буюу 13258.7 мянган төгрөгөөр тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг үр дүнгийн тайлангийн зардлын 1 хувиар буюу 18978.2 мянган төгрөгөөр тооцсон тул төлөвлөлтийн үе шатанд тооцсон материаллаг байдлын түвшнээс 5719.5 мянган төгрөгөөр их гарсан байна.

Гүйцэтгэлийн явцад шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илэрсэнгүй.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 757867.8 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 52562.0 мянган төгрөгөөр буюу 7.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт


Үзүүлэлт	(мян.төг)		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	181,811.2	162,178.2	(19,633.0)
Бараа материал	181,811.2	162,178.2	(19,633.0)
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	523,494.6	595,689.7	72,195.1
Үндсэн хөрөнгө	673,528.2	857,994.0	184,465.8
Хуримтлагдсан элэгдэл	(150,033.5)	(262,304.3)	(112,270.8)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>705,305.8</b>	<b>757,867.9</b>	<b>52,562.0</b>
Өр төлбөр	-	60.7	60.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	705,305.8	757,807.2	52,501.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>705,305.8</b>	<b>757,867.9</b>	<b>52,562.0</b>

Эх сурвалж: Байгууллагын 2020 оны санхүүгийн тайлан

Тус байгууллагын төрийн сан банкны 2 харилцах данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Өмнөх онд авлага, өглөггүй ажилласан ба тайлант онд үйлдвэрчний эвлэлийн татварыг шилжүүлэх гүйлгээг төрийн сан банкаар 2020.12.22-ны өдөр хийсэн боловч гүйлгээ батлагдаагүй байхад санхүүжилт буцаан татсанаас шалтгаалж оны эцэст өглөг үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 162178.2 мянган төгрөг болж өмнөх оноос 19633.0 мянган төгрөгөөр буурсан ба тайланд МЭЭГ-аас 83963.1 мянга, “Био комбинат” УУГ-аас 159037.5 мянга, УМЭАЦТЛ-аас 9151.3 мянга, нийт 252151.9 мянган төгрөгийн эм, био бэлдмэлийг үнэ төлбөргүй авч, ТӨБЗГ-ын даргын 2020.12.22-ний өдрийн А/1-2313 дугаар тушаалаар бараа материалд бүртгэсэн үндсэн хөрөнгийн шинжтэй 43321.7 мянган төгрөгийн 4 ширхэг хөрөнгийг үндсэн хөрөнгөд шилжүүлсэн, тайлант онд 220119.6 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 449605.7 мянган төгрөгийг зарцуулсан зэрэгтэй холбоотой байна.



Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оны эцэст 673528.2 мянган төгрөг байсан ба өмнөх оноос 184465.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байгаагийн 43321.7 мянган төгрөгийн хөрөнгө нь ТӨБЗГ-ын даргын 2020.12.22-ний өдрийн А/1-2313 дугаар тушаалаар, 143116.0 мянган төгрөгийн хөрөнгө нь МЭЕГ-ын 2020.04.13-ний өдрийн А/99, 2020.04.29-ний өдрийн А/142 дугаар тушаалаар үнэ төлбөргүй авсан хөрөнгүүд байна. Тайлант хугацаанд 9742.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан ба төсвийн хөрөнгийг зарцуулах шийдвэрийг байгууллагын дарга хөрөнгө худалдан авсны дараа гаргажээ. ТӨБЗГ-ын даргын 2020.12.22-ний өдрийн А/1-2313 дугаар тушаалаар 11713.9 мянган төгрөгийн 14 нэр төрлийн үндсэн хөрөнгийг акталсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүн 52501.4 мянган төгрөгөөр нэмэгдэж 757807.2 мянган төгрөг болсон байна.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын улсын төсвөөс авах санхүүжилт өмнөх оноос 44898.5 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар өссөн бөгөөд, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого өмнөх оноос нэмэгдээгүй 2000.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн байна.

Нийт зардал өмнөх онд 665144.8 мянган төгрөг байсан бол тайлант оны зардал өмнөх оноос 32757.7 мянган төгрөгөөр буюу 1.77 хувиар өсөж, 697902.5 мянган төгрөг гарсан нь өмнөх оны үзүүлэлтээс урсгал шилжүүлгийг 1376.3 мянга, бараа үйлчилгээний зардлыг 31381.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн өөрчлөгдөөгүй бөгөөд тайлант жилийн үр дүн тайлангуудад зөв бүртгэгдсэн байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх улсын төсвийн санхүүжилтийг 941147.1 мянган төгрөг авч, өөрийн орлогыг 2000.0 мянган төгрөгөөр төлөвлөж, нийт зарлагыг 943147.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.


Анхны батлагдсан төсөв	2020 оны 12 сард хийсэн тодотгосон төсөв	Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 283241.0 мянган төгрөгөөр бууруулж, 657906.1 мянган төгрөгийг баталж, 12 дугаар сард төсвийг 52587.0 мянган төгрөгөөр тодотгож, 710493.1 мянган төгрөгөөр баталсан бөгөөд хөдөлмөр хамгааллын хэрэгсэл худалдан авах, урсгал засвар, бараа үйлчилгээний бусад
657906.1	710493.1	зардлыг нэмэгдүүлж баталжээ.

Тус байгууллага МЭЕГ-аас баталсан 58 орон тоогоор ажиллахаас гүйцэтгэлээр 54 орон тоогоор ажилласан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 708493.1 мянган төгрөгийн төсөв баталж, өөрийн орлогоор 2000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс авахаар батлагдсан 708493.1 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, туслах үйл ажиллагааны орлогоор 2080.1 мянган төгрөг оруулж, урсгал үйл ажиллагаанд 697902.5 мянган төгрөгийг зарцуулан, оны эцэст 12670.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.



Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 842289.7 мянган төгрөгийн санхүүжилт орсон байна.

Хүснэгт 2. Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн ажлын санхүүжилт /төгрөгөөр/

Д/д	Санхүүжилтийн төрөл	Авсан санхүүжилт
1	Аймгийн орон нутгийн төсвөөс баталсан мал эмнэлгийн вакцинжуулалтын үйлчилгээний хөлс	709,193,000
2	Баянхонгор аймгийн орон нутгийн нөөц хөрөнгөөс олгосон ажилтны орон сууцны дэмжлэг	5,000,000.00
3	Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораториос олгосон тандалт шинжилгээний зардал	17,470,240
4	Мал эмнэлгийн Ерөнхий газраас олгосон галзуу, боом өвчний үйлчилгээний төлбөр	110,626,550
ДҮН		842,289,790

Эх сурвалж: Байгууллагын 2020 оны санхүүгийн тайлан, дансны хуулга

Оны эцэст Баянцагаан сумын Мал эмнэлгийн цогцолбор барихад зориулсан 20000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг тендер зарлаж амжаагүй, зураг төсөв батлагдаагүйн улмаас МЭЕГ-т буцаасан байна.

Аймгийн орон нутгийн төсвөөс мал эмнэлгийн үйлчилгээний хөлсөнд 709306.0 мянган төгрөгийг олгохоор баталж, 709193.0 мянган төгрөг олгож, 113.0 мянган төгрөгийг дутуу олгожээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 144 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 3 мэдээлэл байгаа ба 4 мэдээлэл хугацаа болоогүй төлөвт байна.

Хүснэгт 3. Шилэн дансанд байршуулсан мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй	Хугацаа хоцроосон мэдээлэл
1	Бүтэн жил	11	11	6	1	4	Худалдан авах ажиллагааны тайлан
2	Хагас жил	4	4	4			
3	Улирал бүр	1	4	4			
4	Сар бүр	3	36	36			
5	Тухай бүр	8	96	94	2		3, 6 дугаар сард 5.0 сая төгрөгөөс дээш орлого, зарлагыг хоцроож оруулсан.
	Нийт	27	151	144	3	4	

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын шилэн данс



### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн илэрсэн 1 зөрчилд зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж, төрийн аудитын байгууллагад зөвлөмжийн хариуг хугацаанд нь гаргаж ирүүлсэн байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар залруулга хийгдээгүй бөгөөд нийт 155901.1 мянган төгрөгийн залруулагдаагүй 13 алдаа зөрчил илэрлээ.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Хүснэгт 5. Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн
1	Зөвлөмж өгсөн	7	4296.8
2	Төлбөрийн акт тогтоосон	3	3883.5
3	Албан шаардлага өгсөн	3	147720.8
4	Сaxилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн		
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн		
	Дүн	13	155901.1

Эх сурвалж: Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл Б501

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 151604.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 3883.5 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 147720.8 мянган төгрөгийн 3 зөрчил албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тайлант онд тээвэр шатахууны зардалд 20655.0 мянган төгрөг батлагдсан ба гүйцэтгэлээр 5.0 мянган төгрөгийг хэмнэж, 20650.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Няrvын шатахууны тайлан нягтлан бодогчийн шатахууны тооцоо бодсон жагсаалтаас зөрүүтэй, оны эцэст шатахууны хэмнэлтийг төвлөрүүлэлгүй өмнөх сарын дунджаас 3 дахин их шатахууныг 12 сард худалдан авч, 5277.7 мянган төгрөгийн шатахууныг нөөцөлсөн ба зайлшгүй ажлын шаардлагаар хэрэглэхээр тооцоход 2638.8 мянган төгрөгийг илүү нөөцөлсөн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Мал эмнэлгийн 2021 оны төсвөөс төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Хувийн мал эмнэлэгт олгосон санхүүжилтийг тулгахад Баянлиг сумын "Баянлиг буянт сүрэг" ХХК-д 1000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг илүү, Богд сумын "Богд Эрдэнэ оргил" ХХК-д 1000.0 мянган төгрөгийг дутуу олгосон байхад санхүүгийн тайланд авлага, өглөгөөр тусгаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: "Баянлиг буянт сүрэг" ХХК-аас Богд сумын "Богд Эрдэнэ оргил" ХХК-д шилжүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Тайлант оны зарим хөрөнгийн зарлагыг түүвэрлэн шалгаж тулгалт хийхэд 04 дүгээр сард олгосон 57 ширхэг бичгийн цаасыг шаардах хуудастай тулган шалгахад 62.5 мянган төгрөгийн 5 ширхэг бичгийн цаасыг анхан шатны баримтгүй зарлагадсан, 05, 09-д олгосон эмийг тулгахад 05-р дугаар сард олгосон ДХХ, ЭХ вакцин, цусан халдвартын вакциныг тулгахад 40.2 мянган төгрөгийн цусан халдвартын вакцин, 141.9 мянган төгрөгийн ДХХ, ЭХ вакциныг анхан шатны баримтгүй зарлагадсан байна.



Шийдвэрлэсэн нь: Байгууллагын нярваар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

4. Аймгийн үндсэн чиглэлд тусгасны дагуу орон нутгийн төсвийн ангилагдаагүй зардлаас "Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газарт гарал үүслийн гэрчилгээний систем нэвтрүүлэх тоног төхөөрөмж нийлүүлэх" ажилд 102500.0 мянган төгрөг баталж, тендер зарлаж, 97229.5 мянган төгрөгөөр "Би Си Ти" ХХК-шалгарч, гэрээг аймгийн Засаг даргатай байгуулж, 41 ширхэг зөөврийн компьютер, утасгүй мини хэвлэгч авсан байна. Дээрх хөрөнгөөс Бөмбөгөр, Баянбулаг, Жаргалант сумын Мал эмнэлгийн тасагт 7114.3 мянган төгрөгийн 3 ширхэг зөөврийн компьютер, 3 ширхэг утасгүй мини хэвлэгчийг олгосон байхад хөрөнгөд орлогоор бүртгээгүй, үлдэх 90115.1 мянган төгрөгийн 38 ширхэг зөөврийн компьютер, утасгүй мини хэвлэгчийг Хувийн мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгжид олгосныг аймгийн Орон нутгийн өмчийн газар хөрөнгөд хэрхэн бүртгэх талаарх шийдвэрийг эрх бүхий байгууллагаар гаргуулаагүй байна. Бэлтгэн нийлүүлэгч байгууллага тендерт шалгарч гэрээ байгуулсан үнийн дүнгээс 412.0 мянган төгрөгөөр илүүгээр нийлүүлэх барааны үнийн хуваарь, нэхэмжлэхийг бичсэн байгаа ба аймгийн Төрийн сан гэрээний нийт дүнгээр 97229.5 мянган төгрөгийг төлсөн байгаа тул гэрээ байгуулсан дүнг үндэслэн хөрөнгийн нэг бүрийн үнийг гаргалаа.

Шийдвэрлэсэн нь: Мал эмнэлгийн тасаг олгосон хөрөнгийг байгууллагын хөрөнгөд бүртгэх албан шаардлагыг Мал эмнэлгийн газарт, хувийн мал эмнэлгүүдэд олгосон хөрөнгүүдийг холбогдох эрх бүхий байгууллагаар шийдвэр гаргуулж, орон нутгийн өмчид бүртгэх албан шаардлагыг аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэхээр шийдвэрлэв.

5. Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2020.04.13-ний өдрийн А/99 дүгээр тушаалаар сумдын мал эмнэлгийн тасгийн шуурхай ажил үйлчилгээнд зориулж нэг бүр нь 2395.8 мянган төгрөгийн үнэ бүхий 20 ширхэг буюу нийт 47916.0 мянган төгрөгийн хөрөнгийг Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газарт хуваарилж, 2020.05.18-ны өдөр хүлээн авч орлогод бүртгэсэн боловч мотоциклийн улсын бүртгэлийн дугаарыг аваагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

6. Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 250.0 мянган төгрөгийн үнэ бүхий угаалгын машин, 2325.3 мянган төгрөгийн үнэ бүхий 3 ширхэг компьютерын ашиглагдах жилийг программд 0 гэж оруулснаас элэгдэл тооцогдоогүй ба бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй, үндсэн хөрөнгөд бараа материалын шинжтэй хөрөнгүүд бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

#### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 4296.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 7 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Санхүүгийн хяналт, аудитын албаны хяналт шалгалтаар шатахуун, томилолттой холбоотой алдаа зөрчил илэрсэн ба Төсвийн тухай хуульд заасан хугацаа богино тул эдгээр зардлуудад нарийвчилсан горим сорил хэрэгжүүлээгүй тул дараагийн аудитаар анхаарах шаардлагатай.

Малын тоо толгой, статистик мэдээнд үндэслэн вакцины хэмжээг зөв тооцон авч төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулах тохиолдол дахин давтагдан гаргахгүй байхад анхаарч ажиллах нь зүйтэй байна.



#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### 1. ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

1.1. **Илрүүлэлт:** Байгууллагын албан хаагчдад олгосон 1320.0 мянган төгрөгийн 40 флаш, 20354.4 мянган төгрөгийн нормын хувцас, 4200.0 мянган төгрөгийн 14 ширхэг гэр интернэтийг ажиллагсдад олгосон байхад бараа материалд үлдэгдлээр байгаа ба аудитын явцад Мал эмнэлгийн газрын ажилтан, албан хаагчдын хэрэглэж буй эд хөрөнгийн ашиглалтын картад эдгээр хөрөнгийг бүртгэсэн эсэхийг шалгахад картад эзэмшиж буй хөрөнгийг бүрэн бүртгээгүй, хөрөнгийн тоо ширхэг, мөнгөн дүнг тавиагүй, эд хариуцагч гарын үсэг зураагүй байна. Тооллогын бүртгэлийн хөрөнгийн дүнтэй тулгахад тохирсон боловч тооллогын дүнг баталгаажуулах тушаалыг байгууллагын дарга гаргаагүй, санхүүгийн тайланд бүртгэлтэй 985.0 мянган төгрөгийн 45 малыг А дансаар баталгаажуулаагүй байна.

Томилолтоор ажиллуулах тушаалыг томилолтоор ажилласны дараа нөхөн гаргасан, 2020.05.27-нд 4942.0 мянга, 2020.11.23-нд 3700.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, тушаалыг 2020.12.18-нд гаргасан ба 2020.04.08-ны өдөр М.Отгонжаргалаас нэг бүр нь 41.5 мянган төгрөгийн үнэ бүхий нийт 829.7 мянган төгрөгийн 20 ширхэг аранз худалдан авах болон туслах аж ахуйгаас 156.0 мянган төгрөгийн үнэ бүхий нийт 8 тоо толгой малыг зарцуулах зэрэгт дарга тушаал гаргалгүй төсвийн хөрөнгийг зарцуулсан байна.

1.2. **Эрсдэл:** Байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл хөтлөлт тавих хяналт сулаас төсвийн хөрөнгө үрэгдэх, дутагдах, төсвийн хөрөнгийг төсвийн захирагчийн шийдвэргүйгээр зарцуулж, холбогдох хуулийг зөрчих.

1.3. **Өгсөн зөвлөмж:** Байгууллагын ажилтан, албан хаагчдын хэрэглэж буй эд хөрөнгийн ашиглалтын картад эд хөрөнгийн үнэ, тоо хэмжээ, нийт дүнг бүрэн бичиж, гарын үсгээр албажуулах; ажилтан ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн тохиолдолд нормын хувцсыг устгалд оруулах; төсвийн хөрөнгийг зарцуулах тушаалыг байгууллагын дарга тухай бүр гаргаж байх; малыг А дансаар баталгаажуулж, баримтыг тооллогын бүртгэлийн баримтад хавсаргах.

1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.

##### 2. ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

2.1. **Илрүүлэлт:** Бараа материалыг олгох шаардах хуудас дээр дарга гарын үсэг зурж баталгаажуулаагүй, шаардах хуудаст огноо бичээгүй, зарим шаардах хуудсыг давхардуулан хийсэн/ 2 удаа бичсэн/, зарим зарлагын падаанд нягтлан бодогч гарын үсэг зураагүй байна. Байгууллагын хэрэгцээнд зарцуулсан малыг тухай бүр нь тушаал гаргаж бүртгэлээс хасаагүй, 12 дугаар сард бөөн дүнгээр зарлага болгосон, агуулахын бүртгэлийг хөтлөөгүй байна.

2.2. **Эрсдэл:** Бараа материалын зарцуулалтад тавих хяналт сул байх, агуулахын бүртгэл хөтлөөгүйгээс хөрөнгө шамшигдуулах, дутагдах.

2.3. **Өгсөн зөвлөмж:** Агуулахын бүртгэлийг тухай бүр хөтөлж, даргаар баталгаажуулсан шаардах хуудаст үндэслэн бараа материалыг олгож, нягтлан бодох бүртгэлийг хөтлөн анхан шатны баримтын бүрдлийг сайжруулах.

2.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.

##### 3. БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.1. **Илрүүлэлт:** Бараа материалын дансанд оны эхэнд үлдэгдлээр байсан 4296.8 мянган төгрөгийн бруцеллэзоц 19-р омгийн вакциныг зарцуулаагүй байгаа ба үүний шалтгааныг аудитын явцад тодруулахад 2019 онд хүлээн авсан, хугацаа нь дууссан вакцин байна. Мэргэжилтний өгсөн тайлбараар "хэрэгцээнээс илүү малын тоо толгойноос их олгосноос зарцуулаагүй ба зарцуулаагүй вакциныг буцаан өгөх хүсэлтийг гаргасан ч

нэгдсэн журмаар татан авч устгал хийнэ гэсэн одоогоор байгаа" гэснээс үзэхэд төсвийн хөрөнгийн үр ашиг гараагүй байна .

3.2. **Эрсдэл:** Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах.

3.3. **Өгсөн зөвлөмж:** Дээд шатны байгууллагаас нийлүүлэх эм, био бэлдмэлийг бодит тоон мэдээлэл тулгуурлан захиалж авах, бараа материалд үлдэгдлээр байгаа хугацаа нь дууссан 4296.8 мянган төгрөгийн бруцеллэзоц 19-р омгийн вакцины асуудлыг дээд шатны байгууллагад тавьж шийдвэрлэх, зөрчлийг дахин давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах.

3.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.

#### 4. ОРЛОГЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

4.1. **Илрүүлэлт:** Тайлант онд төсвийн хуваарийн дагуу өөрийн орлогоор 2000.0 мянган төгрөг оруулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 2080.1 мянган төгрөг орсон байна. Аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулахдаа шинжилгээний төлбөрийг хэдэн төгрөгөөр хийхийг тусгаагүй, гэрээ байгуулсан аж ахуйн нэгжээс орлого ороогүй, байгуулсан гэрээ дүгнэж ажиллаагүй, 2020 оны 12 дугаар сард шинжилгээний төлбөрт 625.0 мянган төгрөгийн орлогыг бөөнд нь харилцах дансанд тушаасан байна.

4.2. **Эрсдэл:** Өөрийн орлогыг тухай бүр харилцах дансанд тушаахгүй байх, орлогыг бүрэн оруулах талаар санаачилга гарган ажиллаагүй байх.

4.3. **Өгсөн зөвлөмж:** Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6 дахь "Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-аас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана" гэснийг хэрэгжүүлэн ажиллах, өөрийн орлогыг нэмэгдүүлэх талаар санаачилгатай ажиллаж, харилцагчидтай байгуулсан гэрээний дагуу үйлчилгээг үзүүлж орлогыг оруулан оны эцэст гэрээг дүгнэж ажиллах.

4.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.

#### 5. ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

5.1. **Илрүүлэлт:** Төсвийн захирагч ээлжийн амралтыг биеэр эдэлж чадаагүй тул үндсэн цалинг 1.5 дахин олгосон асуудлыг аймгийн СХАА шалгаж, төлбөрийн акт тогтоосон байхад 2020 онд төсвийн захирагч дээд шатны байгууллагын шийдвэрээр дахин авсан асуудал гарсан ба ямар шалтгааны улмаас амраагүй талаарх баримт материалыг анхан шатны баримтад хавсаргаагүй байна. Зарим албан хаагчийн цалингийн шатлалыг тооцсон байдлыг шалгахад цалингийн шатлалыг буруу тогтоосон байх эрсдэлтэй байгаа ба аудитын цаг хугацааны хувьд үүнийг шалгах боломжгүй тул зөвлөмж өгч дараагийн аудитаар шалгахад шийдвэрлэв.

5.2. **Эрсдэл:** Ажилтанд үндэслэлгүй цалин олгох, цалин тогтоолтыг буруу тогтоох, цалингийн зардлыг хэтрүүлэх.

5.3. **Өгсөн зөвлөмж:** Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-т заасны дагуу ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх, албан хаагчдын цалинг ажилласан хугацааг харгалзан үзэн зөв тогтоох.

5.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.

#### 6. ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

6.1. **Илрүүлэлт:** Хувийн мал эмнэлгүүдэд санхүүжилтийг хуваарилсан анхан шатны баримтыг санхүүгийн баримтад үдээгүй, зарим хувийн мал эмнэлэг батлагдсан анхан шатны маягтаар гүйцэтгэлээ гаргаагүй, аж ахуйн нэгжүүдийн э-баримтыг бүрэн авч санхүүгийн баримтад хавсаргаагүй, боом, галзуугийн вакцины нэхэмжилсэн нэхэмжлэхийн дүнд үйлчилгээний хөлсний тарифт өөрчлөлт орж буурсан байхад анхан шатны баримтыг өөрчлөөгүй гүйлгээ хийсэн байна

6.2. **Эрсдэл:** Төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сул, анхан шатны баримтыг бүрэн үдээгүй байх.

6.3. **Өгсөн зөвлөмж:** Хувийн мал эмнэлгүүдэд олгох хуваарийг байгууллагын даргаар батлуулж, санхүүгийн баримтад хавсаргах, зардлын зарцуулалтын баримтын үнэн зөв, бүрэн байдалд тавих хяналтыг сайжруулж, е-баримтыг бүрэн авч, баримтад үдэх.

6.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.

7. ТӨСВИЙН ӨМНӨ ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

7.1. **Илрүүлэлт:** Шилэн дансанд нийт 147 мэдээлэл байршуулснаас 2 мэдээлэл хоцроож мэдээлсэн, НИК ХХК-аас шатахуун худалдан авах гэрээг байгуулж, сар бүр худалдан авалт хийж байгаа атлаа шилэн дансанд худалдан авалтын мэдээллийг бүрэн оруулаагүй, мал эмнэлгийн үйлчилгээний батлагдсан үнэ тарифыг мэдээлээгүй байна.

7.2. **Эрсдэл:** Төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо бүрдүүлэхгүй байх.

7.3. **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, худалдан авалт, үйлчилгээний төлбөрийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулах.

7.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг холбогдох нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АХЛАХ АУДИТОР .....

Б.ДОЛЖМАА

Огноо: 2021.02.23

Анхан шатанд хянасан:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН  
МЕНЕЖЕР .....

А.ЦЭЭНЯМ

Огноо: 2021.02.23

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛӨХ  
АУДИТОР .....

Б.МӨНХБАТ

Огноо: 2021.02.23


## 5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.22	Аудитын нэр: <b>Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд</b>	Аудитын код: БНА-2021/185/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: <b>Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар</b>	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	5
1	Тайлант оны эцэст шатахууны хэмнэлтийг төвлөрүүлэлгүй, өмнөх сарын дунджаас 3 дахин их шатахууныг 12 сард худалдан авч, 5277690 төгрөгийн шатахууны үлдэгдэлтэй гарсан ба тайлант онд зарцуулсан шатахууны гүйцэтгэлтэй харьцуулахад оны эцэст 2,638,845 төгрөгийн шатахууныг хэрэгцээнээс илүү нөөцөлсөн.	2638.8	Төлбөрийн акт тогтоох	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Л.Оюун-Эрдэнэ, С.Цэнд-Аюуш
2	Хувийн мал эмнэлэгт олгосон санхүүжилтийг тулгахад Баянлиг сумын "Баянлиг буянт сүрэг" ХХК-д 1,000,000 төгрөгийн санхүүжилтийг илүү, Богд сумын "Богд Эрдэнэ оргил" ХХК-д 1,000,000 төгрөгийг дутуу олгосон байхад санхүүгийн тайланд авлага, өглөгөөр тусгаагүй.	1000.0	Төлбөрийн акт тогтоох	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Л.Оюун-Эрдэнэ, С.Цэнд-Аюуш
3	Түүврийн аргыг ашиглан зарим бараа материалын зарлагыг шаардах хуудастай тулган шалгахад 04 дүгээр сард 62500 төгрөгийн 5 ширхэг бичгийн цаас, 05 дугаар сард 40246 төгрөгийн цусан халдвартын вакцин, 141913 төгрөгийн ДХХ, ЭХ вакциныг анхан шатны баримтгүй зарлагадсан.	244.7	Төлбөрийн акт тогтоох	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Л.Оюун-Эрдэнэ, С.Цэнд-Аюуш
4	Аймгийн үндсэн чиглэлд тусгасны дагуу орон нутгийн төсвийн ангилагдаагүй зардлаас "Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газарт гарал үүслийн гэрчилгээний систем нэвтрүүлэх тоног төхөөрөмж нийлүүлэх" ажилд 102500000 төгрөг баталж, тендер зарлаж, 97229500 төгрөгөөр "Би Си Ти" ХХК-шалгарч, гэрээг аймгийн Засаг даргатай байгуулж, 41 ширхэг зөөврийн компьютер, утасгүй мини хэвлэгч авсан байна. Дээрх хөрөнгөөс Бөмбөгөр, Баянбулаг, Жаргалант сумын Мал эмнэлгийн тасагт 7114354 төгрөгийн 3 ширхэг зөөврийн компьютер, 3 ширхэг утасгүй мини хэвлэгчийг олгосон байхад хөрөнгөд орлогоор бүртгээгүй, үлдэх 90115138 төгрөгийн 38 ширхэг зөөврийн компьютер, утасгүй мини хэвлэгчийг Хувийн мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг ААН-д	97229.5	Албан шаардлага өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Л.Оюун-Эрдэнэ, С.Цэнд-Аюуш

**Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

	олгосныг аймгийн ОНӨГ хөрөнгөд хэрхэн бүртгэх талаарх шийдвэрийг эрх бүхий байгууллагаар гаргуулаагүй байна.				
5	Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2020.04.13-ний өдрийн А/99 дүгээр тушаалаар сумдын мал эмнэлгийн тасгийн шуурхай ажил үйлчилгээнд зориулж нэг бүр нь 2395800 төгрөгийн үнэ бүхий 20 ширхэг буюу нийт 47916000 төгрөгийн хөрөнгийг Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газарт хуваарилж, 2020.05.18-ны өдөр хүлээн авч орлогод бүртгэсэн боловч мотоциклийн улсын бүртгэлийн дугаарыг бүртгүүлээгүй байна.	47916.0	Албан шаардлага өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Л.Оюун-Эрдэнэ, С.Цэнд-Аюуш
6	Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 250000 төгрөгийн үнэ бүхий угаалгын машин, 2325325 төгрөгийн үнэ бүхий 3 ширхэг компьютерийн ашиглагдах жилийг программд 0 гэж оруулснаас элэгдэл тооцогдоогүй ба бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй, үндсэн хөрөнгөд бараа материалын шинжтэй хөрөнгүүд бүртгэсэн байна.	2575.3	Албан шаардлага өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Л.Оюун-Эрдэнэ, С.Цэнд-Аюуш
7	Бараа материалыг олгох шаардах хуудас дээр дарга гарын үсэг зурж баталгаажуулаагүй, шаардах хуудаст огноо бичээгүй, зарим шаардах хуудсыг давхардуулан хийсэн/ 2 удаа бичсэн/ , зарим зарлагын падаанд нягтлан бодогч гарын үсэг зураагүй байна. Байгууллагын хэрэгцээнд зарцуулсан малыг тухай бүр нь тушаал гаргаж бүртгэлээс хасаагүй, 12 дугаар сард бөөн дүнгээр зарлага болгосон, агуулахын бүртгэлийг хөтлөөгүй.	0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Л.Оюун-Эрдэнэ, С.Цэнд-Аюуш
8	Ажиллагсдад олгосон бараа материалыг ажилтан, албан хаагчдын хэрэглэж буй эд хөрөнгийн ашиглалтын картад бүрэн бүртгэж, хөрөнгийн тоо ширхэг, мөнгөн дүнг тавиагүй, эд хариуцагч гарын үсэг зураагүй, хөрөнгө захиран зарцуулах шийдвэрийг байгууллагын дарга тухай бүр нь гаргаагүй, нөхөн гаргасан, бүртгэлд тусгасан малыг А дансаар баталгаажуулаагүй.	0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Л.Оюун-Эрдэнэ, С.Цэнд-Аюуш
9	Бараа материалын дансанд оны эхэнд үлдэгдлээр байсан 4296831 төгрөгийн бруцеллёзоц 19-р омгийн вакцинийг зарцуулаагүй байгаа ба үүний шалтгааныг аудитын явцад тодруулахад 2019 онд хүлээн авсан, хугацаа нь дууссан вакцин байна. Мэргэжилтний өгсөн тайлбараар "хэрэгцээнээс илүү малын тоо толгойноос их олгосноос зарцуулаагүй ба зарцуулаагүй вакциныг буцаан өгөх хүсэлтийг гаргасан ч нэгдсэн журмаар татан авч устгал хийнэ гэсэн одоогоор байгаа" гэснээс үзэхэд төсвийн хөрөнгийн үр ашиг гараагүй.	4296.8	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Л.Оюун-Эрдэнэ, С.Цэнд-Аюуш
10	Тайлант онд төсвийн хуваарийн дагуу өөрийн орлогоор 2000000 төгрөг оруулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 2080100 төгрөг орсон байна. Аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулахдаа шинжилгээний төлбөрийг хэдэн төгрөгөөр хийхийг тусгаагүй, аж ахуйн нэгжээс орлого ороогүй, байгуулсан гэрээ дүгнэж ажиллаагүй, 2020 оны 12 дугаар сард шинжилгээний төлбөрт 625000 төгрөгийн орлогыг бөөнд нь харилцах дансанд тушаасан	0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Л.Оюун-Эрдэнэ, С.Цэнд-Аюуш



**Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

11	Төсвийн захирагч ээлжийн амралтыг биеэр эдэлж чадаагүй тул үндсэн цалинг 1.5 дахин олгосон асуудлыг аймгийн СХАА шалгаж, төлбөрийн акт тогтоосон байхад 2020 онд төсвийн захирагч дээд шатны байгууллагын шийдвэрээр дахин авсан асуудал гарсан баямар шалтгааны улмаас амраагүй талаарх баримт материалыг анхан шатны баримтад хавсаргаагүй байна. Зарим албан хаагчийн цалингийн шатлалыг тооцсон байдлыг шалгахад цалингийн шатлалыг буруу тогтоосон.	0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Л.Оюун-Эрдэнэ, С.Цэнд-Аюуш
12	Шилэн дансанд нийт 147 мэдээлэл байршуулснаас 2 мэдээлэл хоцроож мэдээлсэн, НИК ХХК-аас шатахуун худалдан авах гэрээг байгуулж, сар бүр хулалдан авалт хийж байгаа атлаа шилэн дансанд худалдан авалтын мэдээллийг бүрэн оруулаагүй, мал эмнэлгийн үйлчилгээний батлагдсан үнэ тарифийг мэдээлээгүй.	0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Л.Оюун-Эрдэнэ, С.Цэнд-Аюуш
13	Хувийн мал эмнэлгүүдэд санхүүжилтийг хуваарилсан анхан шатны баримтыг санхүүгийн баримтад үдээгүй, зарим хувийн мал эмнэлэг батлагдсан анхан шатны маягтаар гүйцэтгэлээ гаргаагүй, аж ахуйн нэгжүүдийн э-баримтыг бүрэн авч санхүүгийн баримтад хавсаргаагүй, боом, галзуугийн вакцины нэхэмжилсэн нэхэмжлэхийн дүнд үйлчилгээний хөлсний тарифт өөрчлөлт орж буурсан байхад анхан шатны баримтыг өөрчлөөгүй гүйлгээ хийсэн.	0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Л.Оюун-Эрдэнэ, С.Цэнд-Аюуш
<b>ДҮН</b>		<b>159901.1</b>			

---oOo---

